



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 39

Мандалговь

Төсөл хэрэгжүүлэх саналыг
дэмжих тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.7 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн 31.1.2 дахь заалт, Дундговь аймгийн Засаг дарга болон Японы Хүүхдийг ивээх сангийн Харилцан ойлголцлын санамж бичгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Хүүхдийг ивээх сангаар Хүмүүнлэгийн туслалцаа үзүүлэх төслийн хүрээнд Шороон шуургын гамшигт өртөж, хохирол амссан тус сумын малчин 60 өрхөд эрүүл мэндийн багц, 20 өрхөд мөнгөн тусламж, 1 өрхөд гэр олгох саналыг тус тус дэмжсүгэй.

2. Хохирол амсаж тус төсөлд хамрагдах өрхийг нарийн судалж, нэрсийг үнэн зөв, бодитой гарган уламжилж, тусламжийг олгуулахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Төслийн үйл ажиллагааг хариуцах эрх бүхий ажилтныг томилон ажиллуулж, төслийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (С.Бат-Оргил)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.БАТЖАРГАЛ